



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 6-р цэцэрлэгийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/160/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг
Сайншанд сум
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуудамж,
3 дугаар баг, Сайшанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.24 № 1-6/199

таний _____-ны № _____-т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ХҮҮХДИЙН
6-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л. ЮМЖИРМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 6-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 6-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 6-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан

0100*04*

"Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтаар төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 80.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 382.8 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 348.5 сая төгрөгийн 23 гүйлгээ, 28.1 сая төгрөгийн 16 шийдвэрийг хугацаа хоцроосон байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнтэй тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад бараа материалын үлдэгдэл 0.4 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 11 харилцагчдаас 6.5 сая төгрөгийн худалдан авалтад ибаримт аваагүй байна. Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй, НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" заалтуудтай нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 10 зорилт, 30 арга хэмжээний хэрэгжилт 90 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 80.6 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т. ГАН-ӨЛЗИЙ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	62,104,303.23	138,097,606.88
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	80,564,421.14
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	80,564,421.14
3121	Төгрөг	-	80,564,421.14
31211	Төрийн сангийн харилцах	-	80,564,421.14
33	АВЛАГА	145,787.47	1,947,047.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	145,787.47	1,947,047.00
35	БАРАА МАТЕРИАЛ	61,958,515.76	55,586,138.74
351	Түүхий эд материал	7,227,900.00	10,834,050.00
35110	Тусгай зориулалттай материал	6,728,000.00	10,541,000.00
35130	Эм боох материал	499,900.00	293,050.00
354	Хангамжийн материал	54,730,615.76	44,752,088.74
35410	Бичиг хэргийн материал	1,212,668.00	1,225,430.00
35420	Аж ахуйн материал	42,699,681.58	32,754,761.54
35440	Түлш, шатах тослох материал	26,000.00	-
35450	Барилгын засварын материал	3,955,100.00	620,000.00
35460	Хүнсний материал	6,245,116.18	10,086,997.20
35470	Бусад хангамжийн материал	592,050.00	64,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	962,179,749.99	950,981,909.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	962,179,749.99	950,981,909.63
392	Биет хөрөнгө	960,525,291.67	949,244,651.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	921,388,166.00	921,388,166.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,325,376.08)	(39,488,064.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,446,923.00	66,512,123.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,169,185.30)	(36,966,383.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,732,814.92	56,054,937.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,025,603.82)	(22,740,270.53)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,364,230.00	10,884,230.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,886,677.05)	(6,400,087.12)
393	Биет бус хөрөнгө	1,654,458.32	1,737,258.36
39301	Програм хангамж	1,927,000.00	2,202,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(272,541.68)	(465,241.64)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,024,284,053.22	1,089,079,516.51
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	270.04	270.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	270.04	270.00
413	Өглөг	270.04	270.00
4136	Бусад өглөг	270.04	270.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.04	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	270.00	270.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,024,283,783.18	1,089,079,246.51
51	Засгийн газрын хувь оролцоо	1,024,283,783.18	1,089,079,246.51
512	Хуримтлагдсан үр дүн	1,024,283,783.18	1,089,079,246.51
51210	Өмнөх үеийн үр дүн	1,024,283,783.18	1,024,283,783.18
51220	Тайлант үеийн үр дүн	-	64,795,463.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,024,284,053.22	1,089,079,516.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	324,321,039.15	433,980,306.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,454,500.00	16,949,144.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,454,500.00	16,949,144.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө	-	1,800,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан Бараа материал	506,500.00	1,519,450.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	948,000.00	2,051,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	948,000.00	2,051,500.00
120009	Бусад орлого	-	11,578,194.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	322,866,539.15	417,031,162.73
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	285,947,500.00	356,295,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	356,295,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	285,947,500.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,325,386.00	-

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	191,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,134,386.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,593,653.15	60,735,562.73
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,593,653.15	60,735,562.73
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	332,464,205.37	368,458,843.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	332,464,205.37	368,458,843.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,708,337.76	362,602,243.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	192,422,695.34	208,474,364.63
210101	Үндсэн цалин	129,658,360.09	166,866,934.05
210102	Нэмэгдэл	48,693,436.98	33,233,903.78
210104	Урамшуулал	14,070,898.27	8,373,526.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,915,722.30	28,159,661.67
210201	Тэтгэврийн даатгал	18,584,165.80	19,653,034.74
210202	Тэтгэмжийн даатгал	2,217,955.99	2,312,948.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,670,449.70	1,702,519.17
210204	Ажилгүйдлийн даатгал	379,195.02	399,123.28
210205	Эрүүл мэндийн даатгал	4,063,955.79	4,092,035.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,238,553.15	35,078,385.76
210301	Гэрэл, цахилгаан	2,704,189.15	4,200,593.76
210302	Түлш, халаалт	25,477,144.00	26,730,616.00
210303	Цэвэр, бохир ус	2,057,220.00	4,147,176.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,448,508.00	1,520,938.00
210401	Бичиг хэрэг	960,000.00	230,676.00
210402	Тээвэр, шатахуун	285,000.00	26,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	220,650.00	-
210404	Ном, хэвлэл	26,400.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,261,800.00	345,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,627,558.00	492,670.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	23,500.00	-
210408	Бараа материал акалсны зардал	43,600.00	425,892.00
2105	Нормативт зардал	11,443,541.82	32,925,698.98
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,900.00	23,950.00
210502	Хоол, хүнс	11,342,641.82	32,036,748.98
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	865,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	791,686.00	7,610,800.00
210604	Урсгал засвар	791,686.00	7,610,800.00
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	-
210702	Дотоод албан томилолт	42,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	619,000.00	264,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	331,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	264,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,786,631.15	48,568,294.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,281,940.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	377,400.00	1,388,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,409,231.15	40,898,254.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,755,867.61	5,856,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	5,856,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	5,856,600.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,555,867.61	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,555,867.61	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(8,143,166.22)	65,521,463.05
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	39,600.00	725,999.72
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	725,999.72
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	30,000.00	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал Бараа материал	9,600.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(39,600.00)	(725,999.72)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(8,182,766.22)	64,795,463.33

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	323,814,539.15	419,228,450.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	948,000.00	2,197,287.47
120	Нийтлэг татварын бус орлого	948,000.00	2,197,287.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	948,000.00	2,197,287.47
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	948,000.00	2,197,287.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	322,866,539.15	417,031,162.73
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	285,947,500.00	356,295,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	356,295,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	285,947,500.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,325,386.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	191,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,134,386.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,593,653.15	60,735,562.73
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,593,653.15	60,735,562.73
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	301,943,339.15	331,714,929.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	301,943,339.15	331,714,929.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	276,187,471.54	325,858,329.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	186,996,752.09	210,421,411.63
210101	Үндсэн цалин	126,391,644.74	169,513,273.28
210102	Нэмэгдэл	47,877,893.93	32,973,836.55
210104	Урамшуулал	12,727,213.42	7,934,301.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,915,722.30	28,159,661.67
210201	Тэтгэврийн даатгал	18,990,500.00	19,660,067.12
210202	Тэтгэмжийн даатгал	2,137,500.00	2,312,948.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,620,485.14	1,702,519.17
210204	Ажилгүйдлийн даатгал	368,459.85	399,123.28
210205	Эрүүл мэндийн даатгал	3,798,777.31	4,085,003.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,238,553.15	35,078,385.76
210301	Гэрэл, цахилгаан	2,704,189.15	4,200,593.76
210302	Түлш, халаалт	23,742,776.00	26,730,616.00
210303	Цэвэр, бохир ус	3,791,588.00	4,147,176.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,576,250.00	-
210401	Бичиг хэрэг	296,700.00	-
210402	Тээвэр, шатахуун	311,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	220,650.00	-
210404	Ном, хэвлэл	118,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,259,400.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,370,000.00	-
2105	Нормативт зардал	20,736,408.00	35,942,380.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,000.00	-
210502	Хоол, хүнс	14,986,408.00	35,942,380.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,700,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,729,486.00	4,284,500.00
210604	Урсгал засвар	4,729,486.00	4,284,500.00
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	-
210702	Дотоод албан томилолт	42,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	619,000.00	264,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	331,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	264,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,333,300.00	11,707,890.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,508,790.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,333,300.00	4,199,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,755,867.61	5,856,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	5,856,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	5,856,600.00

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,555,867.61	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,555,867.61	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	21,871,200.00	87,513,521.14
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	21,871,200.00	6,949,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,871,200.00	6,949,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,871,200.00	6,949,100.00
223001	Бусад хөрөнгө	21,871,200.00	6,949,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(21,871,200.00)	(6,949,100.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	80,564,421.14
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	80,564,421.14

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,030,730,903.30	1,030,730,903.30
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,870,032.10	3,870,032.10
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,034,600,935.40	1,034,600,935.40
C07	Тайлант үеийн үр дүн	(10,317,152.22)	(10,317,152.22)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,024,283,783.18	1,024,283,783.18
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,024,283,783.18	1,024,283,783.18
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,024,283,783.18	1,024,283,783.18
D08	Тайлант үеийн үр дүн	64,795,463.33	64,795,463.33
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,089,079,246.51	1,089,079,246.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	420,294,000.00	338,664,029.06	81,629,970.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	420,294,000.00	338,664,029.06	81,629,970.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	414,437,400.00	332,807,429.06	81,629,970.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	268,248,600.00	210,421,411.63	57,827,188.37
210101	Үндсэн цалин	229,470,000.00	169,513,273.28	59,956,726.72
210102	Нэмэгдэл	32,537,000.00	32,973,836.55	(436,836.55)
210104	Урамшуулал	6,241,600.00	7,934,301.80	(1,692,701.80)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,489,900.00	28,159,661.67	5,330,238.33
210201	Тэтгэврийн даатгал	22,773,100.00	19,660,067.12	3,113,032.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,679,200.00	2,312,948.84	366,251.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,143,300.00	1,702,519.17	440,780.83
210204	Ажилгүйдлийн даатгал	535,900.00	399,123.28	136,776.72
210205	Эрүүл мэндийн даатгал	5,358,400.00	4,085,003.26	1,273,396.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,745,500.00	35,078,385.76	1,667,114.24
210301	Гэрэл, цахилгаан	4,967,200.00	4,200,593.76	766,606.24
210302	Түлш, халаалт	26,730,600.00	26,730,616.00	(16.00)
210303	Цэвэр, бохир ус	5,047,700.00	4,147,176.00	900,524.00
2105	Нормативт зардал	52,000,900.00	35,942,380.00	16,058,520.00
210502	Хоол, хүнс	52,000,900.00	35,942,380.00	16,058,520.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,400,000.00	7,804,500.00	595,500.00
210604	Урсгал засвар	8,400,000.00	7,804,500.00	595,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,000.00	539,600.00	52,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	539,600.00	52,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,960,500.00	14,861,490.00	99,010.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,760,500.00	10,662,390.00	98,110.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,200,000.00	4,199,100.00	900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,856,600.00	5,856,600.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,856,600.00	5,856,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,856,600.00	5,856,600.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	420,294,000.00	419,228,450.20	1,065,549.80
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	356,295,600.00	356,295,600.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	356,295,600.00	356,295,600.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	62,998,400.00	60,735,562.73	2,262,837.27
132001	Орон нутгийн төсвөөс	62,998,400.00	60,735,562.73	2,262,837.27
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	2,197,287.47	(1,197,287.47)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	2,051,500.00	(1,051,500.00)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		80,564,421.14	(80,564,421.14)
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20.00	20.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	-
620003	Үйлчлэх ажилтан	9.00	9.00	-
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	166.00	166.00	-
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	166.00	166.00	-
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	166.00	166.00	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 10.1 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Бараа материалын ангиллаас үндсэн хөрөнгийн дансанд 10.1 сая төгрөгийн хөрөнгийг ангилал сольж бүртгэхдээ үр дүнгийн тайланд орлого, зардлаар бүртгэснийг;
2. Төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй ирснийг залруулав.

Аудитаар нийт 4 зөрчил² илэрснээс 0.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард үндсэн цалингийн 80 хувиар буюу 0.8 сая төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.3 Зөвлөмж

1. Тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнтэй тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад бараа материалын үлдэгдэл 0.4 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, дутагдах үр дагавартай.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг бодитой, чанартай хийж, тооллогын үр дүнгээр холбогдох мэдээллүүдийг тодорхой тусгаж /хэзээ, ямар дансыг, аль өдрийн үлдэгдлээр тоолсон эсэх/, акт үйлдэж байх.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 382.8 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 348.5 сая төгрөгийн 23 гүйлгээ, 28.1 сая төгрөгийн 16 шийдвэрийг хугацаа хоцроосон байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансанд холбогдох мэдээллүүдийг тогтоосон хугацаанд үнэн зөв, бүрэн оруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

3. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын тулгалтаар 11 харилцагчдаас 6.5 сая төгрөгийн худалдан авалтад ибаримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй, НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж : Худалдан авалтыг тооцоо хийгдсэн тухай бүрд нь цаасан болон цахим ибаримтыг үндэслэн санхүүгийн тайланд тусгаж ажиллах.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын ангиллаас үндсэн хөрөнгийн дансанд 10.1 сая төгрөгийн хөрөнгийг ангилал сольж бүртгэхдээ үр дүнгийн тайланд орлого, зардлаар бүртгэснийг	1	10,099.1	0	-	1	10,099.1	1	10,099.1	0	-		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй ирсэн.	1		0	-	1		1		0	-		
Дүн	2	10,099.1	-	-	2	10,099.1	2	10,099.1	-	-		

